

ИРГЭДЭД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

Монгол Улсын Засгийн газар “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ыг шинэчлэн баталснаар
БИЧИЛ УУРХАЙЧДАД таатай орчин бүрдлээ.



Ашигт малтмал олборлох гэрээг сум, (дүүрэг)-ын Засаг даргатай тухайн талбайн ашигт малтмалыг ашиглаж дуусах хүртэлх хугацаагаар байгуулна.



Нөхөрлөл, хоршооны зохион байгуулалтад орж хуулийн этгээд болсноор банк, санхүүгийн байгууллагатай харьцах, өөр төрлийн бизнес эрхлэх, санхүүжилтийн асуудлаа шийдвэрлэхэд дөхөмтэй болно.



Иргэд Иргэний хуульд заасны дагуу нэгдэж, нөхөрлөл, хоршооны зохион байгуулалтад орж сум, (дүүрэг)-ын Засаг даргаас бичил уурхайн ажилтны үнэмлэх авснаар талбай дээр ашигт малтмал олборлох эрхтэй болно.



Бичил уурхайд ашиглагдах тоног төхөөрөмжийн хүчин чадлыг 7 дахин нэмэгдүүлсэнтэй холбогдуулан нөхөрлөл, бүртгэгдээгүй нөхөрлөл нь 9-өөс доошгүй гишүүдтэй байхаар журамласнаар санхүүгийн чадавх сайжирч, орон нутгийн ажил орлогогүй иргэдийг олноор хамруулснаар ажлын байрны тоо нэмэгдэнэ.



Нөхөрлөл, хоршооны ашиглах тоног төхөөрөмжийн хүчин чадлыг 500см³ байсныг 3500см³ болгож нэмэгдүүлснээр орчин үеийн техник, технологи ашигладаг боллоо. Улмаар Та бүгдийн ажлын бүтээмж, ашиг орлого нэмэгдэж, нөхөн сэргээлт хийхэд амар хялбар болно.



Бичил уурхайд ашиглах техникийн хүчин чанал нэмэгдэж, олборлолтын хэмжээ өссөнөөр олборлосон алтыг Монголбанкны итгэмжлэгдсэн төлөөлөгчид зах зээлийн үнээр тухайн орон нутагтаа борлуулах нөхцөл бүрдэнэ.



Бичил уурхайчид нь ашигт малтмал олборлож, тодорхой хэмжээний орлого олж байгаа Монгол Улсын иргэний хувьд хуулиар ногдуулсан албан татвар төлөх үүргээ биелүүлснээр нийгмийн халамж, хамгааллын болон төрийн үйлчилгээний хүртээмж нэмэгдэнэ.



Орон нутагт ажлын байр нэмэгдсэнээр өрхийн орлого болон бэлэн мөнгөний эргэлт нэмэгдэж, ядуурал буурна.



Нөхөн сэргээлтийг төлөвлөгөө, аргачлалын дагуу хийснээр бичил уурхайчдын нийгэм болон байгаль орчны хариуцлага сайжирч, иргэд эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөл бүрдэнэ.